



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар A/162

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ  
шинэчлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7, 21 дүгээр зүйлийн 21.3.2, 28.1.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын ирүүлсэн хүсэлт, газар эзэмшигч иргэн Батдэлгэр овогтой Сайнбаян (ЙТ86020114)-ийн өргөдлийн дагуу аймгийн инженерийн шугам сүлжээтэй бүс тэлсэнтэй холбоотой Мөрөн сумын 13 дугаар баг Чимэдийн толгойд байршилтай 6712015652 нэгж талбарын дугаар бүхий төмс, хүнсний ногооны усалгаатай тариалангийн газрын зориулалттай 1.0106га (10106<sup>2</sup>) газрын гэрээ, гэрчилгээг шинэчлэн өмнө олгогдсон шийдвэрийн газар эзэмших хугацаанаас эзэмшсэн хугацааг хасаж тооцон үлдсэн 3 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзүл)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

6710010487